

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ /№9/

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 3 дугаар зүйлийн 3.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэг талаас Сэлэнгэ аймаг (хот)-ийн Баянгол сум, (дүүрэг)-ын Засаг дарга С. Ариунбат (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас "Минж Наран Эгэрэх" нэхорлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж цахирал (албан тушаал) Д. Болдбаатар нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож **2018 оны 08** дугаар сарын **22** -ны өдөр энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) Баянгол сум (дүүрэг)-д байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Баянгол сум (дүүрэг)-ийн Баян багийн нутаг дэвсгэрт орших Бүянт нэртэй газрын **2.9** гектар талбай буюу дараах солбицолд

Д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	106	30	58.7	49	9	29.83
2	106	30	58.58	49	9	27.95
3	106	30	53.15	49	9	26.41
4	106	30	42.3	49	9	28.62
5	106	30	33.94	49	9	30.98
6	106	30	31.94	49	9	32.85
7	106	30	44.54	49	9	32.75
8	106	30	44.83	49	9	29.87
Талбайн га						2.9

энэхүү журмын 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу үүсмэл алт (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

ХОЁР. СҮМ (ДҮҮРЭГ)-ЫН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Сүм (дүүрэг)-ын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах,
- 2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;
- 2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох,
- 2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр юухих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.5 бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах,

2.1.6 энэхүү гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах,

2.1.7 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох

ГУРАВ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах,

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цогийг байгуулах,

3.1.4 гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх,

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, гөрхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сургалчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалын ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх,

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай догоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байр аль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх,

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах,

3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх,

3.1 16 Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах

ДОРОВ. ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1 Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.
- 4.2 Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдэж шаардана.
- 4.3 Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана.

ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1 Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.
- 5.2 Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 6.1 Энэхүү гэрээ нь 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгөнөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.
- 6.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

ДОЛОО. ГЭРЭЭНИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 7.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 7.2 Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь талууд нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛС

Баянша аймаг (кот)-
 нийслэл Баянша сум (дүүрэг)-ын
 Засаг дарга *[Signature]*
 /эцэг/ *[Signature]* -ийн нэр, нэр, гарын үсэг, тамга,
 тэмдэг

"*[Signature]*" (нөхөрлөл,
 /эцэг/ *[Signature]* -ийн нэр, нэр, гарын үсэг, тамга,
 тэмдэг

[Vertical signature]